



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 07 дугаар сарын 17
№26 (1274)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

314.Хөтөлбөр соёрхон батлах тухай	1731
315.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1732
316.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1734
317.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1736
318.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1738

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

319. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 44	1740
320. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 52	1747

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

321. Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 04	1749
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

322. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк (АХБ) хоорондын 2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр	1757
------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------

5048.	5048 - 5049. évi törvény a Magyar Köztársaságban érvényesülő pénzügyi jogszabályok alkalmazásáról		1925
5049.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5049.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5050.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		1925
5050.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5051.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5052.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5053.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5054.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5055.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		1925
5056.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		1925
5057.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5058.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5059.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		
5060.	Magyar Föld_ az Föld Föld_ az KF* I		



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХӨТӨЛБӨР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан “2022-2023 оны зээлийн төлөвлөгөөний Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын
Их Хурлын
Дарга

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт, дэд заалт нэмсүгэй:

1/25 дугаар зүйлийн 25.7.5.г дэд заалт:

“25.7.5.г.эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой.”

2/25 дугаар зүйлийн 25.8.11 дэх заалт:

“25.8.11.давж заалдах шатны шүүх хуралдаанд бэлтгэх ажлын бүрдэл, хугацааны хуваарилалт, дарааллыг тогтоох, бэлтгэл хуралдаан хийх журмыг хэлэлцэж, батлах.”

2 дугаар зүйл. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а, 25.7.5.б дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“25.7.5.а.шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;
25.7.5.б.хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн;”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Индриг Фою на Ноги

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -

Индриг Фою на Ноги, 2023 он №26/1274/ - 9 -



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 123.2.4 дэх заалт нэмсүгэй:

“123.2.4.эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой.”

2 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсэг:

“118.3.Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ.”

2/123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалт:

“123.2.1.шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”

3/123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалт:

“123.2.3.хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн;”

3 дугаар зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

᠕ᠮᠠᠭᠤᠨ ᠪᠠᠭᠠᠳᠤᠨ ᠰᠤᠭᠤᠭᠤᠰᠤᠨ ᠶ᠋ᠢᠨ

Мэдээлэл ба Үг

ᠵᠢᠰᠤᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠰᠤᠭᠤᠭᠤᠰᠤᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ

ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1.4 дэх заалт нэмсүгэй:

“1.4.эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/40.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт:

“1.1.шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”

2/40.1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт:

“1.3.хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн;”

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн эсэх” гэснийг “шүүхийн Эрүүгийн хуулийн хэрэглээний зөрүү байгаа эсэх” гэж, “албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж” гэснийг “тогтоол, тайлбараас өөрөөр” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 172.2.4 дэх заалт нэмсүгэй:

“172.2.4.эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой.”

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалт:

“172.2.1.шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;”

2/172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалт:

“172.2.3.хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн;”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
АМГААГАХ АНГАМЫН
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМЫН
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМЫН
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМЫН
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМЫН

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ
МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ

МОНГОЛЫН ХӨДӨӨ ХАМГААГАХ АНГАМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан хугацаанд багтаан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулах ажлыг зохион байгуулахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд даалгасугай.

3.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр байгуулагдах Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж Төрийн ордны барилга байгууламж, нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны танхим, өрөө тасалгааны зохион байгуулалттай холбогдох зураг төсөл, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн өөрчлөлт хийхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж, бусад шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын 3-т заасан арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

5.Энэ тогтоол баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т даалгасугай:

1/Улсын Их Хурлын Тамгын газрын бүтэц, орон тоо, цалингийн сан, үйл ажиллагааны төсвийн төслийг боловсруулж, шийдвэрлүүлэх;



2/Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, эрх зүйн бусад актыг боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллах.

6.Энэ тогтоолыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2023 оны
44 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН
ӨӨРЧЛӨЛТӨД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ
НИЙЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

Д/д	Нэр	Хугацаа
1.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулган
2.	Улс төрийн намын тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулган
3.	Монгол Улсын Төрийн ордны тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган
4.	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган
5.	Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган
6.	Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон холбогдох бусад хууль	Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган
7.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль	Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулган

---oOo---

Монгол Улсын Их Хурлын 2023 оны
44 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
ДҮНГЭЭР БАЙГУУЛАГДАХ УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ЭХЛЭХЭД ШААРДАГДАХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Мөнхбаатар -Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их
Хурлын дэд дарга

Гишүүд:

Н.Энхболд -Улсын Их Хурлын гишүүн, Төрийн
байгуулалтын байнгын хорооны дарга

Г.Тэмүүлэн -Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн
байнгын хорооны дарга

Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн, Сангийн
сайд

Д.Амарбаясгалан -Монгол Улсын сайд, Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын дарга

Л.Өлзийсайхан -Улсын Их Хурлын Ерөнхий нарийн
бичгийн дарга

Л.Алтангэрэл -Төрийн тусгай хамгаалалтын газрын
дарга

Ж.Тамир -Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газрын
дарга

Г.Ариунбуян -Онцгой байдлын ерөнхий газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Ц.Батбаатар -Улсын Их Хурлын Тамгын газрын дэд
дарга

---oOo---

Madrigal Folio oa Vekle Horde oa Dvaelgega

᠒᠐᠒᠔ оны ᠔ сарын ᠒᠒ -н өдөр

᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒

᠒᠐᠒᠔ оны ᠔ сарын ᠒᠒

᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр
᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр

᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр
᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр

᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр
᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр

᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр
᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр

᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр
᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр

᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр
᠒᠐᠒᠔ оны ᠒ сарын ᠒᠒ өдөр



Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр
2023 оны 6 сарын 26-ны өдөр
2023 оны 6 сарын 26-ны өдөр

Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр
2023 оны 6 сарын 26-ны өдөр
2023 оны 6 сарын 26-ны өдөр

№	Тайлбар	Тайлбар
0.6	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр
0.6	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр
0.6	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр
0.6	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр
0.6	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр
0.6	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр
0.6	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр	Үүн бүртгэл нь 2023 оны 6 сарын 26-ны өдөр 2023 оны 6 сарын 26-ны өдөр



Үснийг үсвэр, мр крнэ үсвэг, мр >>д үср, в
дэ крнн үсвэгн мр > крнн үсвэгн мр

Үснийг үсвэр, мр крнэ үсвэг, мр >>д үср, в үснийг
үснийг үсвэр, мр крнэ үсвэг, мр >>д үср, в үснийг
үснийг үсвэр, мр крнэ үсвэг, мр >>д үср, в үснийг
үснийг үсвэр, мр крнэ үсвэг, мр >>д үср, в үснийг

үсн мр үсн мр үсн :

үсн . үсн үсн үсн

үсн :

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн

үсн . үсн үсн үсн :

үсн . үсн үсн үсн



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалт, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Хууль зүйн болон Төсвийн байнгын хорооны хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн”, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “ ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Л.МӨНХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2023 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Онцгой албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 17.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Ч.Цолмонбат, А.Энхтүвшин, Э.Эрдэнэцэцэг болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 4, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалт тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг.Монгол Улсын иргэн Ч.Цолмонбат, А.Энхтүвшин, Э.Эрдэнэцэцэг нар Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж газрын тосны үйлдвэрийн зарим нэр төрлийн завсрын бүтээгдэхүүнд “дайвар бүтээгдэхүүн” гэсэн нэршлээр онцгой албан татвар тогтоосон. Тодруулбал, үйлдвэрлэгч автобензин, дизелийн түлшийг анхан шатны нэрлэг, сайжруулалтын процесс, гүн боловсруулалт гэсэн үе шатуудыг дамжин боловсруулалт хийсний үр дүнд гарган авдаг байна. Харин импортлогч нь ийнхүү үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирдэг.

Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, импортлогчдын эцсийн зорилго, хүрэх үр дүн нь улс эх орныхоо зах зээл, хэрэглээнд



шаардлагатай байгаа бүтээгдэхүүнийг нийлүүлэх, тус бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд ээлтэй өртөг зардал багатай болгох явдал юм. Гэтэл Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эцсийн бүтээгдэхүүн буюу бензин, дизель түлш импортлогч нарт давуу байдал үүсгэж, түүхий эд импортлон эх орондоо нэмүү өртөг үүсгэж байгаа үндэсний үйлдвэрлэгч нарт ялгамжтай хандах нөхцөлийг шууд бүрдүүлсэн байна. Хууль батлах замаар адил тэгш өрсөлдөх боломжийг хязгаарлаж, улмаар үндэсний үйлдвэрлэл хөгжих боломж нөхцөлийг хумьж, зөвхөн бензин, дизель түлш импортлогч нарт давуу байдал үүсгэж, импортын түүхий эд ашиглан, нэмүү өртөг шингээж эх орондоо үндэсний үйлдвэрлэл эрхэлж байгаа үйлдвэрлэгч нарт өртөг, зардлын ачаалал үүсгэх замаар ялгамжтай хандах нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь шударга ёсны зарчимд үл нийцэх юм. Мөн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь газрын тосны боловсруулалтын завсрын олон төрлийн бүтээгдэхүүнээс зөвхөн керосин, хүнд фракцын дизелийн түлш, нафта, алкилатад уян хатан нөхцөл, сонгох боломжгүйгээр тухайлбал, дизелийн түлшний хувьд тонн тутамд 0-21750 төгрөгийн татварын интервал байсаар байтал ямар ч интервалгүй шууд 285 000 төгрөгийн онцгой албан татвар ногдуулахаар хуульчилсан нь тэгш байдлын зарчимд нийцэхгүй.

Хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасан “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;” бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг баримтлах ёстой. Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад “хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан;”-г хууль тогтоомжийн төсөлд хавсарган өгнө гэж заасан. Уг заалтын дагуу хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө хууль санаачлагч албан ёсны цахим хуудсандаа хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан холбогдох судалгаа, тайланг байршуулж, хууль тогтоомжийн төсөлд санал авахаар байна. Тус нэмэлт, өөрчлөлттэй холбоотой үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгаа, тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулж хүн амд танилцуулаагүйгээс үзвэл тус хуулийн төсөлтэй холбоотойгоор үзэл баримтлал батлагдаагүй, танилцуулга, судалгаа, тайланг хийгээгүй болохыг илтгэж байна.

Хууль нь нийгэмд эерэг сайн өөрчлөлт бий болгохын зэрэгцээ улс орны эдийн засаг хүн амын амьжиргаанд дарамт, сөрөг нөлөөлөл болох

тохиолдол ч байдаг тул шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, түүнд тулгуурласан үзэл баримтлал, танилцуулгагүйгээр хуулийг шууд бичих нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчимд нийцэхгүйн зэрэгцээ хууль дээдлэх ёсны зарчмыг зөрчсөн явдал мөн.

Засаг төрийн зүгээс сүүлийн үед эрчимтэй авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрийн үр дүнд газрын тосны үнийн өсөлт, хомсдолоос хамааралтай эдийн засгийн сорилтод иргэд өртөхгүй байх боломж бүрдсэн боловч зарим нэг Үндсэн хуулийн зарчим, үзэл санаанд нийцээгүй концепцын алдаатай хууль тогтоомжийн улмаас тэрхүү бий болгосон эдийн засгийн баталгаа даруй алдагдаад байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг зөрчсөн талаар хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргаж өгнө үү." гэсэн агуулга бүхий мэдээлэл гаргажээ.

Хоёр. Монгол Улсын иргэн Г.Ганцэцэг Үндсэн хуулийн цэцэгд хандаж:

"Монгол Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан онцгой албан татвар ногдуулах барааны жагсаалтад 4.1.5 дахь заалтаар "газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин." гэж нэмсэн байна. Мөн хуульд газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн гэдэгт хүнд фракцын дизелийн түлш, нафта, алкилатыг ойлгоно гэж тайлбарлажээ. Ийнхүү тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 10-т зааснаар "Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосины биет нэгжийн 1 тонн тутамд 285 000 төгрөгөөр хатуу тогтоож, онцгой албан татвар ногдуулахаар хуульчилсан.

Монгол Улсын Их Хурал аливаа хуулийн төслийг боловсруулахдаа судалгаа, нотолгоо үр дүнд суурилж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох ёстой байтал төсөв бүрдүүлэх зорилгоор, шууд хатуу



тогтоосон татвар ногдуулах замаар зөвхөн түүхий эд импортолж байгаа үндэсний үйлдвэрлэгч нарыг ялгаварлан татварын дарамтад оруулж, улмаар зах зээлийн үнэ өсөх, хэрэглэгчдийн худалдан авах чадвар буурах нөхцөл байдлыг бий болгож байна. Энэ нь манай улсын эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Иймд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дээр дурдсан заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг, мөн Тавдугаар зүйлийн 4, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь тус тус зөрчсөн болохыг тогтоож өгнө үү.” гэсэн агуулга бүхий мэдээлэл гаргажээ.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин”, 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, биет нэгж 1 тонн, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосины биет нэгжийн 1 тонн тутамд 285 000 төгрөг гэж тус тус заасан нь үндэсний үйлдвэрлэл хөгжих боломжийг хааж, импортлогчид давуу байдал бий болгох, татварын дарамтад оруулах, зах зээлийн үнэ өсгөх, судалгаа нотолгоогүй хандсан зүйл биш юм. Энэхүү газрын тосны дайвар бүтээгдэхүүн болон керосинд татвар ногдуулах нь хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учирч болох олон тэрбум төгрөгийн хохирлоос урьдчилан сэргийлсэн, шударга ёсонд нийцсэн, энгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн бодит байдлыг хангах хуулийн зохицуулалт юм.

Онцгой албан татвар бол бохирдуулагч зүйлд буюу хүн, байгальд сөрөг нөлөөтэй аливаа бараа, үйлдвэрлэл, үйлчилгээнд ногдуулдаг татвар юм. Өөрөөр хэлбэл, ашиглалтын үр дүн нь хүний эрүүл мэнд, эдийн засаг, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг архи, тамхи, шатахуун зэрэг онцгой объектод ногддог татвар. Өнөөдөр газрын тосны бүтээгдэхүүний зарим үйлдвэрлэлд газрын тосны дайвар бүтээгдэхүүн, керосин зэргийг хольж найруулан хямд зардлаар стандарт бус шатахууныг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх явдал гарсаар байгаа. Энэ нь нэг талаараа хямд өртөгтэй бүтээгдэхүүн гаргаж байгаа мэт боловч холбогдох эрх бүхий байгууллагуудаас хийсэн хяналт шалгалтаар уг найруулсан шатахуун нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ялгаруулж буй хорт бодисын

хэмжээ асар өндөр, эргээд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн явах эд ангийг муутган эвдрэлд оруулж асар их эдийн засаг, санхүүгийн хохирол учруулж байгаа талаар холбогдох салбарын яам, мэргэжлийн хяналтын газраас мэдээлж ирсэн. Энэ ч агуулгаар уг бохирдуулагч ихтэй бүтээгдэхүүний хэрэглээг татварын бодлогоор хязгаарлах нь төрөөс иргэдийнхээ эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн чухал бодлого гэж үзэж, холбогдох газрын тосны дайвар бүтээгдэхүүн, керосинд онцгой албан татварыг ногдуулсан.

Татварыг зөвхөн хуулиар ногдуулдаг тул энэхүү татвар ногдуулах эсэх шийдвэр нь Улсын Их Хурлын Онцгой бүрэн эрхэд хамаардаг. Иймээс ч Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхийн хүрээнд хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглагдаж буй дайвар бүтээгдэхүүн, керосинд онцгой албан татвар ногдуулж байгаа нь Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хийгдэж буй үйлдэл юм.

Иймд дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасныг тус тус зөрчөөгүй гэж үзэж байна." гэсэн байна.

Дөрөв. Дээрх маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газраас тайлбар, баримт, судалгаа, лавлагааг гаргуулан авч судлан үзсэн болно.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 6, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 10 дахь заалтуудад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд онцгой албан татвар ногдуулахаар нэмэлт оруулжээ.



Төрийн санхүү, зээл, татвар, мөнгөний бодлого нь иргэдийн амьжиргаа, эдийн засаг, үйлдвэрлэл зэрэгт шууд нөлөөлдгийг харгалзан шинээр татвар тогтоох, эсхүл өөрчлөхдөө хууль тогтоогч холбогдох тооцоо судалгаанд үндэслэхийн зэрэгцээ төрийн бусад бодлоготой уялдуулах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцүүлэх ёстой. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтад хууль тогтоомжийн төсөлд уг төслийн үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайланг хавсаргахаар заасан. Гэтэл Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох судалгаа бүрдүүлбэрийн хамт өргөн мэдүүлсэн байх боловч дүгнэлт, судалгаа нь иж бүрэн бус, бодит байдалд нийцээгүй, түүнчлэн тухайн хуулиар зохицуулах харилцаанд оролцогч талуудын эрх зүйн байдал болон улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх асуудлыг тусгаагүй байна.

Тухайлбал, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээс үзэхэд тус хуулийн төслийн үр дагаврын талаарх дүгнэлт болон бусад баримт мэдээлэл нь хуулийн төслийн танилцуулга, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан судалгаанд тусгаагаагүй болохыг тэмдэглэсэн байна. Мөн Монгол Улсын Засгийн газар уг хуулийн төсөл нь газрын тосны дайвар бүтээгдэхүүн, керосин зэргийг өөр зориулалтаар ашигладаг импортлогч, үйлдвэрлэгч, хэрэглэгч нарт татварын дарамт, аж ахуйн үйл ажиллагааны хүндрэл үүсгэж болзошгүй байгааг анхаарах ёстой гэсэн санал, дүгнэлт гаргажээ.

Дээрхээс үзэхэд, Монгол Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан гэж үзэхээр байна.

2.Аливаа улс татварын тогтолцоогоо бүрдүүлэхдээ үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, нийгмийн хөгжлийг хангах зорилгыг үндсэн шалгуур болгох хүрээнд хууль тогтоогч татварын хуулийг батлахдаа судалгаа, нотолгоо, үр дүнд суурилж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох шаардлагатай.

Гэтэл бүрэн бус судалгаанд үндэслэн, татварын суурийг өргөжүүлэхдээ газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд холбогдуулан онцгой албан татварыг шатлалгүйгээр тогтоосон нь

түүхий эд импортолж байгаа үндэсний үйлдвэрлэгч нарт ялгамжтай байдал бий болгосон байна. Энэ нь Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчмыг зөрчиж, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар заасанд нийцэхгүй байна.

Иймд Онцгой албан татварын тухай хуулийн маргаан бүхий заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын холбогдох хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн”, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000 төгрөг” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчөөгүй байна.

3.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалтуудыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32



дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Г.ТУУЛХҮҮ

ГИШҮҮД

Ш.СОЛОНГО

Б.БУЯНДЭЛГЭР

Г.БАЯСГАЛАН

Ж.ЭРДЭНЭБУЛГАН

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС БОЛОН АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ) ХООРОНДЫН 2022-2023 ОНЫ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР

ҮҮНЭЭС

(А) Монгол Улс АХБ-аас Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хяналтын тайлан (2022-2024)-д заасан 2022-2023 оны хөгжлийн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор зээлийн санхүүжилт хүсэж болно.

(Б) Монгол Улс, АХБ ерөнхий хөтөлбөр (“Ерөнхий хөтөлбөр”) байгуулах хүсэлтэй байгаа ба энэ хүрээнд Монгол Улс АХБ-аас зээлийн санхүүжилт хүсэх, мөн АХБ-аас зээлийн санхүүжилтийн нөхцөлийг бий болгоно.

ИЙМЭЭС талууд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 1.01. Доор дурдсан Хэсэг 1.02 болон 1.03-т заасны дагуу Монгол Улсын хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор АХБ нь 2022-2023 онд зээлийн санхүүжилт олгож болно.

а) Зээлийн санхүүжилтийн хэмжээ нь 2022-2023 онд зургаан зуун тавин таван сая (655,000,000.0)¹ ам.доллараас хэтрэхгүй байх ба үүнийг АХБ-ны энгийн эх үүсвэр болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.²

Хэсэг 1.02. Хөгжлийн төсөл, эсхүл хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ-тай харилцан тохиролцож байгуулах зээлийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийн ерөнхий мэдээлэл Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хяналтын тайлан (2022-2024)-д туссан байна. Монголын талын хөрөнгө оруулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвараас чөлөөлнө. Монгол Улс татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэн, өөрийн нутаг дэвсгэрт ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татварын чөлөөлөлтийг АХБ-ны зүгээс санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрт Монголын талын оруулж буй хамтарсан хөрөнгө оруулалтад тооцно.

¹ Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн Хэсэг 1.01(а)-т заасан нийт дүн/тааз нь Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хяналтын тайлан (2022-2024)-д заасан Олон шатлалт санхүүжилтийн хөтөлбөр болон түүний шатуудын дүнг оруулаагүй болно.

² Энэхүү Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хяналтын тайланд заасан жилүүдийн дүн хэтэрсэн тохиолдолд АХБ-нд бичгээр мэдэгдсэн байх шаардлагатай.

Хэсэг 1.03. АХБ нь хөгжлийн төсөл, хөтөлбөр тус бүрийн хувьд зөвхөн Монгол Улсаас хүргүүлсэн зээлийн санхүүжилтийн хүсэлтийн дагуу, мөн АХБ-ны Захирлуудын зөвлөлийн зөвшөөрлийн үндсэн дээр олгоно. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс нь заавал зээл хүсэх, эсхүл АХБ нь заавал зээл олгох үүрэг хүлээхгүй болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 2.01. АХБ-ны энгийн эх үүсвэрээс олгох энгийн зээлийн нөхцөл нь (а) 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгож буй энгийн зээлд хамаарах АХБ-ны Энгийн үйл ажиллагааны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.02. АХБ-ны энгийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөл нь (а) 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгож буй хөнгөлөлттэй зээлд хамаарах АХБ-ны Энгийн үйл ажиллагаа (хөнгөлөлттэй)-ны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.03. Монгол Улс нь АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, эсхүл хөтөлбөрийг АХБ-ны авлигын эсрэг арга хэмжээ, хамгаалал, жөндөр, худалдан авалт, зөвлөх үйлчилгээ болон зээлийн ашиглалтын бодлогууд мөн холбогдох зээлийн хэлэлцээр болон бусад зээлийн баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 3.01. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг талуудын ил тод байдлын болон/эсхүл мэдээлэл хүргэх тухай бодлогын дагуу нийтэд ил тод болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 4.01. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох ба 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр байна. Энэхүү хөтөлбөрийг талууд бичгээр тохиролцсоны дагуу сунгаж болно. Талуудын аль нэг Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг нөгөө талтайгаа зөвшилцсөний үндсэн дээр хүчингүй болгож болно.

- Заалтуудын төгсгөл -

Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.

Хөтөлбөрийг 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчин төгөлдөр байна.

**МОНГОЛ УЛСЫГ
төлөөлж**

ЖАВХЛАН БОЛД
Сангийн сайд

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ
төлөөлж**

ПАВИТ РАМАЧАНДРАН
Азийн хөгжлийн банкны Монгол
дахь суурин төлөөлөгч



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003